



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар A/55

Мандалговь

Барилга, байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/406 дугаар “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг байгуулах тухай” захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн Луус сумын соёлын төвийн их засвар ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга: Б.Буманбаатар (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд Ж.Уянга (Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ч.Нацагдорж (Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч)

М.Нямдорж (Зураг төсөл зохиогч “Нануто” ХХК-ийн архитектор)

Б.Амарбаяр (Гүйцэтгэгч “Би Юу Эм Ди” ХХК-ийн захирал)


Б.Амгалан (Луус сумын соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Т.Уранбайгаль (Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга)

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хууль, дүрмийн дагуу ажиллаж, барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн дүгнэлт гарган, танилцуулахыг комисс (Э.Энхмэнд)-т даалгасугай.

ДАРГА

Э.ЧАГНААДОРЖ



D/ Alban bichig/ Tushaal/ 2024.10.22
43-43102000